

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР
НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

.....оны... сарын өдөр

Дугаар:

Чойбалсан хот

Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй “Степ Голд” ХХК /MV-017111/-тай нутгийн захиргааны байгууллага дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжил, хүний хөгжлийг дэмжих асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжил, хүний хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглалтын болон бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр дэмжих

2.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах, уг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

2.1.3. Байгаль орчныг хамгаалах талаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хийх, олборлолтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэсэн тохиолдолд сөрөг нөлөөллийг арилгуулах талаар арга хэмжээг авч ажиллах, хууль бус үйл

ажиллагааг таслан зогсоох

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тохиолдолд уг үүргээ биелүүлтэл, гарсан зөрчлийг арилгах хүртэл хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах

2.1.5. Орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр үзүүлсэн дэмжлэг, туслалцаа, түүний зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар тухайн орон нутгийн иргэдэд мэдээлэл хийж саналыг нь авах, тайланг аймгийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөл”-д хүргүүлэх

2.1.6. Энэхүү гэрээний 3.1.4-т заасан аймгийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлсэн мөнгөн дэмжлэгийн 30 хувийг тухайн тусгай зөвшөөрөлтэй талбай орших сумын Орон нутгийн хөгжлийн санд тухай бүр шилжүүлэх.

2.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг холбогдох байгууллагатай хамтран иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах

2.1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг.

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу шат шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх

3.1.2. Нутгийн захиргааны байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах

3.1.3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд Монгол улсын хууль, тогтоомж эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг хүндэтгэн биелүүлж, тавьсан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн орон нутаг /Дорнод аймаг болон Цагаан-Овоо сум/-ийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг болгож 2019 онд 440.000.000 /дөрвөн зуун дөчин сая/, 2020 онд 700.000.000 /долоон зуун сая/ төгрөг, түүнээс хойш жил бүр 50.000.000 /тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж 2024 онд 900.000.000 /есөн зуун сая/ төгрөг, 2025 онд 1.000.000.000 /нэг тэр бум/ төгрөг, 2026 оноос жил бүр 1.500.000.000 /нэг тэр бум таван зуун сая/ төгрөгийг Дорнод аймгийн

орон нутгийн хөгжлийн сан /Төрийн сан банк 100070052400 тоот данс/-д шилжүүлнэ. Төгрөгийн ханшны өөрчлөлт, инфляцын түвшнээс хамаарч 2026 оноос хойш үзүүлэх мөнгөн дэмжлэгийн хэмжээнд өөрчлөлт оруулж болно.

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 3.1.4-т заасан сайн дурын үндсэн дээр үзүүлэх тухайн оныхоо мөнгөн дэмжлэгийг дөрвөн тэнцүү хуваан ногдох хэсгийг улирал бүрт багтаан Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн санд бүрэн шилжүүлнэ.

3.1.6. Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл авах

3.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг аймгийн уул уурхайн салбарын цахим хаягт ил тод нээлттэй байршуулах

3.1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үйл ажиллагааны явцад тусгай зөвшөөрөлтэй талбайд орших булаг шанд бүхий газрыг хөндөхгүй, ургамал, ан амьтан, байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй ба түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалж ажиллана.

3.1.9. Гамшгийн үед тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх

3.1.10. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл болон орон нутагтай хамтран ажиллах гэрээний талаар орон нутгийн иргэдэд жил бүрийн 4, 10 дугаар саруудад танилцуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тэдний саналыг үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжүүлэн ажиллах

3.2. Ажиллагсдын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцлийн талаар:

3.2.1. Монгол ажилтан ажиллагсдын амьдрах орчин нөхцлийг Монгол улсын холбогдох стандартад нийцүүлнэ.

3.2.2. Монгол ажилтан, ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Монгол улсын Засгийн газраас баталсан нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрээр Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт тогтоосон цалингийн жишгээс доошгүйгээр тогтооно.

3.2.3. Ажилтан, ажиллагсдын амьдрах байр, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчинг эрүүл, ахуйн стандартын дагуу тохижуулж, ажилтан, ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд бүрэн хамруулна.

3.2.4. Ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хуваарьт сургалтыг улирал тутам тогтмол зохион байгуулж, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд хүргүүлэх

3.3. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

3.3.1. Ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, сөрөг нөлөөлөл бий болж, байгаль орчны бохирдол үүссэн тохиолдолд нөхөн сэргээх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгч, 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажиллана.

3.3.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нутгийн захиргааны байгууллагын саналыг тусгана.

3.3.3 Ашигт малтмал олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ус хамгийн багаар хэрэглэгддэг тэргүүний дэвшилтэт, технологи нэвтрүүлж ажиллах ба үйлдвэрлэлд ашигласан усыг дахин ашиглаж ажиллана.

3.4. Зам тээвэр дэд бүтцийн чиглэлээр:

3.4.1. Тосон хулстайн байгалийн нөөц газраар бүтээн байгуулалт, бүтээгдэхүүн тээвэрлэлтийг гүйцэтгэхгүй байх, тээвэрлэлтийн явцад олон салаа зам, хөрсний доройтол үүсгэхгүй байх,

3.4.2. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн автозамын засвар арчлалтыг бүрэн хариуцна

3.5. Ажлын байр нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авалт хийх чиглэлээр:

3.5.1. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг шаардлагатай сургалтад хамруулан ажлын байраар хангах талаар орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах

3.5.2. Орон нутгийн оюутнуудыг дадлага хийх нөхцөл боломжоор хангана.

3.5.3. Уурхайн нийт ажилтан, ажиллагсдын 75-аас доошгүй хувийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан холбогдох журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж авна.

3.5.4. Уурхайн ажилтан, ажиллагсадыг сонгон шалгаруулж авахдаа Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагад бүртгэлтэй Цагаан-Овоо болон Дорнод аймгийн иргэдээс тэргүүн ээлжинд сонгон авна.

3.5.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн үйл ажиллагаандаа шаардагдах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг тухайн оны эхний сард багтаан аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.5.5. Тухайн орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт давуу эрх олгон орон нутгаас нийлүүлэх боломжтой бараа, ажил, үйлчилгээ, худалдан

авалтын 80-аас доошгүй хувийг тухайн орон нутгийн татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгж болон тухайн сумын иргэд, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

4.1. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид “Хороо” гэх)-г төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна. Иргэдийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн хурлаас нэр дэвшүүлнэ.

4.2. Хорооны ажиллах журмыг аймгийн Засаг дарга батлах бөгөөд бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга нэр дэвшүүлж, аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна.

Тав. Тайлагнах, дүгнэх

5.1. Хамтын ажиллагааны хороо нь гэрээний биелэлтэд жил бүр хяналт тавьж, тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

5.2. Талууд Хамтын ажиллагааны хорооны тайлантай танилцан, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа дэвшүүлэн, тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар тухайн сумын Засаг дарга иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Зургаа. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу зохих хариуцлага хүлээх бөгөөд энэ нь хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Талуудын хооронд гэрээтэй холбоотой үл ойлголцол, маргаан үүссэн тохиолдолд хэвийн ажиллагааг хангах нөхцөлөөр харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээний хугацаа, гэрээг цуцлах

7.1. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд үйлчилнэ.

7.2. Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзсан, удаа дараа ноцтой зөрчсөн тохиолдолд нөгөө талын санаачлагаар гэрээг цуцалж болно.

7.3. Гэрээг зөвхөн хууль болон энэ гэрээнд заасан үндэслэлээр цуцална.

7.4. Гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болно

7.5. Талуудын аль нэг нь байгалийн болон гэнэтийн давагдашгүй нөхцөл байдлын

улмаас гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээс харилцан чөлөөлөгдөнө.

Найм. Бусад

8.1. Хамтын ажиллагааны энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусад туслан гүйцэтгэгч нарт нэгэн адил үйлчилнэ.

8.2. Талууд гэрээний 5.1-т заасан тайланг харгалзан гэрээг дүгнэж шаардлагатай тохиолдолд аль нэг талын санаачлагаар харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг байна.

8.3. Гэрээг Монгол хэлээр 3 хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

АЖ АХУЙ НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

“СТЕП ГОЛД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.БАТАА

ЦАГААН-ОВОО СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМАГНАЙ

“СТЕП ГОЛД” ХХК-ИЙН
МЕНЕЖЕР Б.АЛТАНБАЯР